



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 15 сарын 04 өдөр

Дугаар А/64

Амардалай

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн "м" заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.7, 32.1.9, 32.1.10, Байгалийн ургамлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, Монгол улсын Засгийн 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 185 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/166 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг:Сумын Цахиурт багийн нутаг дэвсгэрийн үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг,байгаль орчинд халгүй, энгийн механик болон утах аргаар тэмцэх арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Золжаргал ( Засаг даргын орлогч)

Гишүүдэд:

Б.Баттогтох ( ХААТ-ийн мэргэжилтэн )

Б.Энхдэлгэр ( Байгаль орчны мэргэжилтэн )

Г.Сосорбурам (2-р багийн Засаг дарга )

Д.Цэнд-Аюуш ( Газрын даамал )

Хоёр: Үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг товлосон хугацаанд чанартай зохион байгуулаж тайлан мэдээг холбогдох газарт хүргүүлж ажиллахыг Ажлын хэсгийн дарга (Л.Золжаргал), гишүүдэд үүрэг болгосугай.



ДАРГА

М.БАЯРСҮХ

4880010087